


БҮЛЭГ .7 ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ТӨРХ БАЙДАЛ, ХҮЙСЭЭР⁶

Энэ бүлэгт шилжих хөдөлгөөний төрх байдлыг хүйсээр, шилжин ирсэн, явсан урсгалыг аймгаар судлана. Дотоод шилжих хөдөлгөөнийг судлахын тулд төрснөөс хойшхи, сүүлийн таван жилийн шилжих хөдөлгөөн гэсэн хоёр аргыг хэрэглэсэн. Зураг 7.1-т төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөний ойлголтыг харуулав. Удахгүй хэвлэгдэх дотоод шилжих хөдөлгөөний сэдэвчилсэн судалгаанд сүүлийн нэг жилийн шилжигсэдийг (байнга оршин суугаа хугацаа дээр үндэслэсэн) хүйсээр ялгаатайгаар судалсан болно.


Зураг 7.1 Төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөн, 2000 оны тооллогоор



Эх үүсвэр: 2000 оны хүн ам, орон сууцны тооллого: Үндсэн үр дүн, ҮСГ, НҮБ-ын ХАС, хуудас. 54

Тооллогын үед төрсөн аймаг, нийслэлээсээ өөр газар байнга оршин сууж байгаа хүнийг төрснөөс хойшхи шилжигсэд гэж үзнэ.

Зураг 7.2 Сүүлийн таван жилд шилжигсэд (5, түүнээс дээш насны хүн ам), 2000 оны тооллогоор



⁶ Шилжих хөдөлгөөний талаар илүү нарийвчилсан судалгаа удахгүй хэвлэгдэх дотоод шилжих хөдөлгөөн, хотжилтын сэдэвчилсэн судалгаанд гарна.

Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн суурьшилт, тархалт, хүйсийн харьцааг аймаг болон байршлаар (хот, хөдөө) тооцож энэ тайлангийн хоёрдугаар бүлэгт тодорхой харуулсан байгаа. Эндээс хөдөлмөрийн бүтээмжтэй эрчүүд хөдөөд олон байхад хот уруу эмэгтэйчүүд олноороо ирж байгаа нь ажиглагдсан. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн шилжих хөдөлгөөний төрх байдлын ялгааг хүйсийн харьцааны ялгаатай байдлаас харж болно.

7.1 Бүс нутаг хоорондын шилжих хөдөлгөөн

1995-2000 онд хүн амын бүс нутаг хоорондын шилжих хөдөлгөөнийг судлахад таван жилийн шилжих хөдөлгөөний чиглэл харагдаж байна. Дүнгээр нь авч үзэхэд Төвийн бүс нутгийн хүн амын 7.0 хувь нь бусад бүс нутаг руу, дийлэнхи нь (6.3 хувь) Улаанбаатар хот руу шилжжээ. Зүүн бүс нутгаас бусад бүс нутаг уруу шилжин явсан хүний эзлэх хувь харьцангуй бага байна. Улаанбаатар хот шилжин ирэгсэдийг хүлээн авдаг хамгийн том газар юм.

Хүснэгт 7.1 Шилжих хөдөлгөөн, бүс нутгаар, хүйсээр, 1995-2000

Бүгд

1995 онд байнга оршин сууж байсан бүс нутаг*	Тооллогын үед байнга оршин суугаа бүс нутаг						
	Бүгд		Төвийн	Зүүн	Баруун	Өмнөд	Улаанбаатар
	Тоо	Хувь	Хувь	Хувь	Хувь	Хувь	Хувь
Бүгд	2127470	100.0	31.2	8.5	20.7	6.7	32.9
Төвийн	674201	100.0	93.0	0.2	0.2	0.3	6.3
Зүүн	192242	100.0	1.1	91.7	0.1	0.6	6.5
Баруун	482787	100.0	3.6	0.1	90.2	0.2	6.0
Өмнөд	147663	100.0	1.5	0.6	0.1	92.0	5.7
Улаанбаатар	623755	100.0	2.1	0.3	0.4	0.5	96.8
Гадаад	6822	100.0	28.6	6.3	19.3	1.7	44.0

* Төвийн бүсэд Архангай, Булган, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Дархан-Уул, Орхон аймаг; Зүүн бүсэд Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймаг, Баруун бүсэд Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймаг, Өмнөд бүсэд Дорноговь, Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр аймаг багтана.

Эрэгтэй

1995 онд байнга оршин сууж байсан бүс нутаг	Тооллогын үед байнга оршин суугаа бүс нутаг						
	Бүгд		Төвийн	Зүүн	Баруун	Өмнөд	Улаанбаатар
	Тоо	Хувь	Хувь	Хувь	Хувь	Хувь	Хувь
Бүгд	1053499	100.0	31.6	8.6	20.9	6.8	32.1
Төвийн	335974	100.0	93.2	0.2	0.2	0.5	6.0
Зүүн	95663	100.0	1.3	92.1	0.1	0.6	5.9
Баруун	240375	100.0	3.7	0.1	90.3	0.2	5.7
Өмнөд	73318	100.0	1.8	0.8	0.2	91.9	5.4
Улаанбаатар	304374	100.0	2.3	0.4	0.4	0.5	96.4
Гадаад	3795	100.0	29.4	6.3	18.1	1.7	44.5

Эмэгтэй

1995 онд байнга оршин сууж байсан бүс нутаг	Тооллогын үед байнга оршин суугаа бүс нутаг						
	Бүгд		Төвийн	Зүүн	Баруун	Өмнөд	Улаанбаатар
	Тоо	Хувь	Хувь	Хувь	Хувь	Хувь	Хувь
Бүгд	1073971	100.0	30.8	8.4	20.6	6.6	33.6
Төвийн	338226	100.0	92.8	0.1	0.2	0.2	6.7
Зүүн	96579	100.0	1.0	91.4	0.1	0.5	7.0
Баруун	242412	100.0	3.5	0.1	90.1	0.1	6.3
Өмнөд	74345	100.0	1.3	0.5	0.1	92.0	6.1
Улаанбаатар	319381	100.0	1.8	0.3	0.3	0.4	97.1
Гадаад	3027	100.0	27.6	6.4	21.0	1.8	43.3

1995 онд Улаанбаатар хотод амьдарч байсан хүн амын 2.1 хувь нь төвийн бүсийн аймгууд руу шилжин явжээ. 1995 онд байнга оршин сууж байсан гадаадын иргэдийн 44.0 хувь нь Улаанбаатар хотод, 28.6 хувь нь Төвийн бүсэд амьдарч байв. Бусад бүс нутгаас Улаанбаатар хот уруу шилжин ирсэн хүмүүсийн дунд эмэгтэйчүүд ялимгүй илүү байна. 1995 онд амьдарч байсан газартаа оршин сууж байгаа хүмүүсийг тооллогын үед судлаж үзэхэд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү шилжих хөдөлгөөнд оржээ. Улаанбаатар хотоос гадна Төвийн бүс нутаг олон шилжин ирэгсэдийг хүлээж авч байна (Хүснэгт 7.1).

7.2 Аймаг хоорондын төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөн

Өмнө дурьдсаны дагуу энэ тайланд хоёр төрлийн шилжих хөдөлгөөний төрх байдлыг судлав. Эхнийх нь төрсөн аймаг, нийслэл, 2000 онд байнга оршин суугаа газар дээр үндэслэсэн төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөн, хоёр дахь нь 1995, 2000 онд байнга оршин сууж байгаа газар дээр үндэслэсэн таван жилийн шилжих хөдөлгөөнийг юм. Хүснэгт 7.2-г шилжин ирэгсэд, шилжин явагдсад, шилжих хөдөлгөөнд оролцоогүй хүний эзлэх хувийг аймгаар үзүүлэв.

Төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөнийг аймгаар авч үзэхэд олон хүмүүс шилжин явдаг эсвэл олон хүмүүс шилжин ирдэг онцлогтой аймгууд байна. Тухайн аймаг, нийслэлдээ төрснөөс хойш амьдарч байгаа хүн амын эзлэх хувийг судлахад хамгийн бага хувь Орхон (29.5 хувь), Говьсүмбэр (33.9 хувь), Дархан-Уул (46.5 хувь) аймагт байна.

Хүснэгт 7.2 2000 оны хүн ам, төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөний байдал, аймгаар, 2000 оны тооллогоор

Аймаг, нийслэл	Бүгд хүн ам	Төрснөөс хойш	Шилжин ирсэн	Шилжин явсан
Бүгд	2373493	74.3	20.7	20.7
Архангай	97091	97.3	2.3	40.3
Баян-Өлгий	91068	97.5	1.0	11.2
Баянхонгор	84779	50.4	0.7	27.3
Булган	61776	80.8	14.1	36.6
Говь-Алтай	63673	98.5	1.2	51.4
Дорноговь	50575	68.1	20.0	26.2
Дорнод	75373	84.9	9.8	17.9
Дундговь	51517	97.5	2.2	27.6
Завхан	89999	82.5	2.2	50.6
Өвөрхангай	111420	93.0	3.0	24.4
Өмнөговь	46858	80.7	5.0	19.5
Сүхбаатар	56166	78.0	3.5	29.4
Сэлэнгэ	99950	64.2	35.1	20.2
Төв	99268	61.6	27.4	37.2
Увс	90037	76.9	1.8	42.0
Ховд	86831	79.2	4.1	32.0
Хөвсгөл	119063	92.6	2.4	22.2
Хэнтий	70946	78.1	13.2	22.9
Дархан-Уул	83271	46.5	52.8	13.0
Улаанбаатар	760077	63.4	18.6	4.6
Орхон	71525	29.5	35.7	5.8
Говьсүмбэр	12230	33.9	31.1	10.8

Шилжин ирэгсэдийн эзлэх хувь Дархан-Уул (52.8 хувь), Төв (27.4 хувь), Сэлэнгэ (35.1 хувь), Дорноговь (20.0 хувь), Орхон (69.9 хувь), Говьсүмбэр (63.5 хувь) аймагт хамгийн өндөр байхад Булган (36.6 хувь), Говь-Алтай (51.1 хувь), Завхан (50.6 хувь), Архангай (40.3 хувь) аймгаас хүмүүс олноороо шилжин явжээ. Эмэгтэйчүүд шилжих хөдөлгөөнд илүү оролцож байгаа эсвэл оролцохгүй үлдэж байгааг судлахад (Хүснэгт 7.3) Улаанбаатар, Говь-Алтай, Баянхонгор, Дорноговь, Өмнөговь, Хөвсгөл гэсэн аймагт төрснөөс хойш амьдарч байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байна. Мөн түүнчлэн Архангай (58.1 хувь), Говь-Алтай (58.8 хувь), Дархан-Уул (52.3 хувь), Улаанбаатар (52.6 хувь), Дундговь (51.8 хувь), Баянхонгор (53.4 хувь) зэрэг аймагт шилжин ирэгсэдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байна.

Хүснэгт 7.3 Төрснөөс хойш шилжигсэдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь, аймгаар, 2000 оны тооллогоор

Аймаг, нийслэл	Бүгд	Төрснөөс хойш	Шилжин ирсэн	Шилжин явсан
Бүгд	50.4	50.2	51.2	51.2
Архангай	50.0	49.8	58.1	51.6
Баян-Өлгий	49.7	49.7	48.4	50.9
Баянхонгор	50.4	50.4	53.4	50.1
Булган	49.6	49.4	50.7	53.2
Говь-Алтай	50.5	50.4	58.8	51.7
Дорноговь	49.6	50.8	44.7	50.8
Дорнод	50.1	50.2	48.5	53.3
Дундговь	50.1	50.0	51.8	50.7
Завхан	50.0	49.9	53.0	50.4
Өвөрхангай	50.1	50.1	49.7	51.0
Өмнөговь	49.9	50.7	34.4	50.1
Сүхбаатар	49.1	49.4	40.5	53.2
Сэлэнгэ	48.9	49.2	48.5	53.5
Төв	48.2	49.1	46.0	52.7
Увс	49.5	49.6	42.1	50.9
Ховд	50.2	50.2	51.1	50.5
Хөвсгөл	50.4	50.4	49.8	52.0
Хэнтий	49.7	49.8	49.4	52.5
Дархан-Уул	51.0	49.5	52.3	50.3
Улаанбаатар	51.4	50.8	52.6	48.3
Орхон	50.6	49.5	51.1	52.6
Говьсүмбэр	49.6	50.6	49.0	51.6

Нийт 21 аймаг, нийслэл хотоос 10 аймагт шилжин ирэгсэдийн дунд эмэгтэйчүүд давамгайлжээ. Харин Өмнөговь (34.4 хувь), Сүхбаатар (40.5 хувь), Увс (42.1 хувь), Дорноговь (44.7 хувь), Төв (46.0 хувь) аймагт шилжин ирэгсэдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь доогуур байна. Булган (53.2 хувь), Говь-Алтай (51.7 хувь), Дорнод (53.3 хувь), Сүхбаатар (53.2 хувь), Сэлэнгэ (53.5 хувь), Төв (52.7 хувь), Хөвсгөл (52.0 хувь), Хэнтий (52.5 хувь), Орхон (52.6 хувь) аймагт шилжин явагсадын дунд эмэгтэйчүүд давамгайлж байна

7.3 Сүүлийн таван жилийн шилжих хөдөлгөөн

2000 оны хүн ам, орон сууцны тооллогоор 1995 онд байнга оршин сууж байсан аймаг, нийслэлийг асууж харьцуулсан. Тооллогын үед 1995 онд байнга оршин сууж байсан аймаг, нийслэлдээ амьдарч байгаа хүний эзлэх хувь Орхон (75.7

хувь), Говьсүмбэр (80.6 хувь), Дархан-Уул (82.1 хувь) аймагт хамгийн доогуур байв.

Хүснэгт 7.4 Тав, түүнээс дээш настай хүн ам, дүнд эзлэх хувь, аймгаар, 2000 оны тооллогоор

Аймаг, нийслэл	5, түүнээс дээш насны хүн ам	1995 онд байнга оршин сууж байсан газартаа тооллогын үед байсан хүн ам	Шилжин ирэгсэд	Шилжин явагсад
Б гд	2127470	91.5	8.5	8.5
Архангай	85203	98.3	1.7	10.7
Баян-Өлгий	78052	98.2	1.8	3.4
Баянхонгор	74409	99.5	0.5	8.2
Булган	55081	92.6	4.3	12.9
Говь-Алтай	56000	99.0	1.0	14.0
Дорноговь	45216	88.5	11.5	10.5
Дорнод	68045	96.4	3.6	9.8
Дундговь	45480	99.0	1.0	11.2
Завхан	79687	97.8	2.7	16.9
Өвөрхангай	98056	97.7	2.3	7.5
Өмнөговь	41322	95.4	4.6	7.1
Сүхбаатар	49965	96.9	3.1	9.2
Сэлэнгэ	85798	88.8	11.1	10.8
Төв	89047	87.5	12.5	17.4
Увс	77690	97.9	2.1	18.0
Ховд	75020	95.8	4.2	9.0
Хөвсгөл	105581	98.1	1.9	7.0
Хэнтий	62938	95.1	4.9	11.3
Дархан-Уул	75735	82.1	17.6	11.4
Улаанбаатар	699112	86.3	13.7	2.9
Орхон	65144	75.7	24.3	9.4
Говьсүмбэр	10883	80.6	19.4	14.6

Хүснэгт 7.5 Сүүлийн таван жилд шилжигсэдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь, аймгаар, 2000 оны тооллогоор

Аймаг, нийслэл	Тав, түүнээс дээш насны хүн ам	1995 онд байнга оршин сууж байсан газартаа тооллогын үед байсан хүн ам	Шилжин ирэгсэд	Шилжин явагсад
Бүгд	50.5	50.6	49.5	49.5
Архангай	50.1	49.9	60.0	50.3
Баян-Өлгий	49.8	49.8	47.7	51.8
Баянхонгор	50.5	50.5	52.3	49.8
Булган	49.6	49.6	49.0	51.0
Говь-Алтай	50.7	50.6	58.7	52.6
Дорноговь	49.3	50.7	38.3	46.7
Дорнод	50.2	50.6	39.8	52.4
Дундговь	50.2	50.1	56.2	49.1
Завхан	50.2	50.2	47.2	50.2
Өвөрхангай	50.2	50.3	47.4	49.2
Өмнөговь	50.1	50.9	32.9	49.3
Сүхбаатар	49.1	49.5	36.3	51.3
Сэлэнгэ	48.8	49.6	42.4	51.6
Төв	48.1	49.7	40.6	50.2
Увс	49.4	49.7	35.6	49.4
Ховд	50.3	50.5	45.7	48.9
Хөвсгөл	50.5	50.6	47.3	50.4
Хэнтий	49.9	50.0	47.0	50.6
Дархан-Уул	51.1	50.9	52.1	49.8

Улаанбаатар	51.6	51.4	52.8	45.3
Орхон	50.7	51.0	49.8	51.3
Говьсүмбэр	49.5	50.6	44.6	49.8

Орхон аймгийн хүн амын бараг дөрөвний нэг нь шилжин ирэгсэд байна. Энэ хувь Говьсүмбэрт 19.4 хувь, Дархан-Уулд 17.4 хувь байна. Увс (18.0 хувь), Төв (17.4 хувь), Завхан (16.9 хувь), Говьсүмбэр (14.6 хувь) аймагт шилжин явагсадын эзлэх хувь хамгийн өндөр байна. Шилжих явагсад нь шилжин ирэгсэдээсээ давж цэвэр шилжих хөдөлгөөн ерөнхийдөө сөрөг урсгалтай байв (Хүснэгт 7.4).

Нийт шилжин ирэгсэдийн дунд эмэгтэйчүүд давамгайлж аймагт Архангай (60 хувь), үүний дараа Говь-Алтай (58.7 хувь), Дундговь (56.2 хувь) аймаг, Улаанбаатар хот (52.8 хувь) орж байна. Харин эмэгтэйчүүдийн эзлэх хувь хамгийн бага аймагт Өмнөговь (32.9 хувь), үүний дараа Увс (35.6 хувь), Сүхбаатар (36.3 хувь) аймаг орж байна. Эдгээр аймгийн онцлогийг судлаж шилжих хөдөлгөөнийг түлхэх, эсвэл турхирах хүчин зүйлсийг тодорхойлох шаардлагатай юм.

Нийтдээ 16 аймагт шилжин явагсадын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь шилжин ирэгсэдийнхээс давж байна (Хүснэгт 7.5).

7.4 Төрснөөс хойшхи шилжигсэдийг сонгосон үзүүлэлтүүд, хүйсээр харьцуулсан байдал

Эрэгтэй, эмэгтэй шилжигсэдийг сонгосон үзүүлэлтүүдээр харьцуулахад сонирхолтой үр дүн гарч байна.

Хүснэгт 7.6 Нийт хүн ам, төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд ороогүй хүмүүс, шилжигсэд, нас, хүйсний бүтцээр, 2000 оны тооллогоор

Насны бүлэг	Шилжих хөдөлгөөнд ороогүй			Шилжигсэд			Бүх хүн ам		
	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	858,673	904,169	1,762,842	319,308	291,343	610,651	1,177,981	1,195,512	2,373,493
0-4	13.9	12.9	13.4	1.6	1.8	1.7	10.6	10.2	10.4
5-9	15.2	14.1	14.6	4.3	4.8	4.5	12.3	11.8	12.0
10-14	16.3	15.4	15.8	6.0	6.6	6.3	13.5	13.2	13.4
15-19	12.6	11.6	12.1	7.8	8.7	8.2	11.3	10.9	11.1
20-24	9.8	9.6	9.7	10.6	10.6	10.6	10.0	9.8	9.9
25-29	8.4	8.5	8.4	11.3	11.0	11.1	9.2	9.1	9.1
30-34	6.3	6.9	6.6	11.9	11.3	11.6	7.9	8.0	7.9
35-39	5.4	5.9	5.6	12.2	11.8	12.0	7.2	7.3	7.3
40-44	3.7	4.3	4.0	9.7	9.0	9.3	5.3	5.4	5.4
45-49	2.3	2.7	2.5	6.6	6.2	6.4	3.4	3.5	3.5
50-54	1.4	1.8	1.6	4.9	4.7	4.8	2.4	2.5	2.4
55-59	1.5	1.8	1.6	4.6	4.2	4.4	2.3	2.4	2.4
60-64	1.2	1.4	1.3	3.3	3.0	3.1	1.8	1.8	1.8
65-69	1.0	1.3	1.1	2.4	2.7	2.5	1.4	1.6	1.5
70-74	0.5	0.8	0.6	1.4	1.6	1.5	0.7	1.0	0.9

75-79	0.3	0.6	0.5	0.9	1.1	1.0	0.5	0.8	0.6
80+	0.2	0.6	0.4	0.5	1.0	0.7	0.3	0.7	0.5

Хүснэгт 7.6-д нийт хүн ам, төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөнд оролцогсодын нас, хүйсний бүтцийг дүнд эзлэх хувийн жингээр харуулав. Төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөнд оролцогсод нь ерөнхийдөө залуу хүмүүс байна. Нийт хүн амын 34.2 хувь 20-39 насныхан байхад төрснөөс хойшхи шилжигсэдийн 45.3 хувь, шилжих хөдөлгөөнд оролцоогүй хүмүүсийн 30.3 хувь нь байна. Эндээс шилжих хөдөлгөөнд тодорхой насны хүмүүс оролцож байгаа нь харагдаж байна. Мөн түүнчлэн 25-39 насны шилжигсэдийн дунд эрэгтэйчүүд давамгайлж байхад 20-24 насны шилжигсэдийн дунд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд ижил байна. Энэ нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол сургуульд суралцахдаа илүү байгаатай холбоотой (Бүлэг 6. Боловсрол бичиг үсгийн мэдлэг, 2000 оны Хүн ам, орон сууцны тооллого: Үндсэн үр дүн).

Тухайн хүний сурч дүүргэсэн сургууль нь түүний боловсролын түвшний талаархи мэдээллийг гаргаж өгдөг. Боловсролоо дээшлүүлэх нь шилжих хөдөлгөөнд оролцох чухал хүчин зүйлсийн нэг юм. Арав, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, шилжих хөдөлгөөний байдал, хүйсийг дүнд эзлэх хувиар харуулсан нь (Хүснэгт 7.7) шилжих хөдөлгөөнд оролцоогүй хүн ам болон шилжигсэдийн боловсролын түвшинээр ялгаатай байдлыг харуулав.

Хүснэгт 7.7 Арав, түүнээс дээш насны хүн ам, боловсролын түвшин, шилжих хөдөлгөөний байдал, хүйсээр, дүнд эзлэх хувиар, 2000 оны тооллогоор

Боловсролын байдал	Шилжих хөдөлгөөнд ороогүй			Шилжигсэд			Бүгд		
	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	608813	660330	1269143	300371	272292	572663	909184	932622	1841806
Боловсролгүй	14.9	13.8	14.3	5.2	5.9	5.5	11.7	11.5	11.6
Боловсролтой	85.1	86.2	85.7	94.8	94.1	94.5	88.3	88.5	88.4
Бага	28.6	27.1	27.8	14.3	13.3	13.8	23.8	23.1	23.5
4-8-р анги	28.0	23.9	25.9	28.9	17.7	23.6	28.3	22.1	25.1
9-10-р анги	17.3	21.1	19.3	22.8	26.9	24.7	19.1	22.8	21.0
Техник мэргэжлийн	3.1	2.7	2.9	5.5	5.3	5.4	3.9	3.4	3.6
Тусгай дунд, бүрэн бус дээд	3.8	6.1	5.0	9.5	17.4	13.3	5.7	9.4	7.6
Дээд	4.4	5.2	4.9	13.9	13.5	13.7	7.6	7.7	7.6

Хүснэгт 7.7-д харуулсан үр дүнгээс харахад шилжих хөдөлгөөнд оролцогсод, шилжих хөдөлгөөнд ороогүй хүмүүсээс харьцангуй өндөр боловсролтой байна. Дүнгээр нь авч үзэхэд шилжигсэдийн дунд боловсролгүй хүмүүсийн эзлэх хувь шилжих хөдөлгөөнд ороогүй хүнийхээс 8.8 пункт, бага боловсролтой хүний эзлэх хувь 14.0 пунктээр тус тус доогуур байна. Шилжигсэдийн дунд 4-8 жилийн боловсрол эзэмшсэн хүний эзлэх хувь эрэгтэйчүүдийн (28.9 хувь) хувьд эмэгтэйчүүдийнхээс (17.7 хувь) өндөр байна. Энэ нь 4-8 жилийн боловсролтой эрэгтэйчүүд сургуульд үргэлжлүүлэн суралцах бус харин ажил хайхаар шилжиж байгааг харуулж байж болно. Харин 10 жилийн боловсрол эзэмшсэн эмэгтэй шилжигсэдийн эзлэх хувь (26.9 хувь) эрэгтэйчүүдийнхээс (22.8 хувь) өндөр байна. Энэ нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол сургуульд суралцахдаа илүү байна гэж тооллогоор гарсныг баталж байна.

7-29 насны бүх хүмүүсийн 47.8 хувь нь (Хүснэгт 7.8) сургуульд суралцаж байна. Сургуульд хамрагдалт шилжих хөдөлгөөнд ороогүй хүмүүсийн хувьд өндөр (49.4 хувь) харин шилжигсэдийн (41.1 хувь) хувьд түүнээс доогуур байна. Үүнд шилжих хөдөлгөөний хүйсийн ялгаатай байдал илт нөлөөлсөн байна. Насаар авч үзэхэд шилжих хөдөлгөөнд ороогүй хүмүүсийн сургуульд хамрагдалт шилжигсэдийнхээс ерөнхийдөө өндөр, энэ ялгаа долоо, найман насанд хамгийн өндөр байна. Арван наснаас эхлээд энэ ялгаа нэмэгдсээр 15 насанд шилжигсэдийн сургуульд хамрагдалт шилжих хөдөлгөөнд ороогүй хүнийхээс 9.5 пунктээр өндөр байна. Товчхондоо төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд ороогүй хүмүүс хүүхдээ нас ахисан хойно нь сургуульд явуулж, удалгүй сургуулиас гаргах нь шилжигсэдтэй харьцуулахад хамаагүй илүү байна.

Хүснэгт 7.8 7-29 насны хүн амын сургуульд хамрагдалт, төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөний байдал, хүйсээр, 2000 оны тооллогоор

Насны бүлэг	Шилжих хөдөлгөөнд ороогүй			Шилжигсэд			Бүгд		
	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд
7-29	46.9	52.0	49.4	35.1	47.5	41.1	44.5	51.1	47.8
7-15	76.8	83.0	79.9	83.4	88.6	86.0	77.6	83.7	80.6
7	26.7	30.9	28.8	31.9	38.2	35.0	27.2	31.7	29.4
8	82.9	85.9	84.4	86.2	89.9	88.1	83.3	86.3	84.8
9	92.3	94.0	93.1	94.2	95.6	94.9	92.5	94.2	93.3
10	92.1	94.2	93.1	95.0	96.4	95.7	92.4	94.5	93.4
11	89.4	93.3	91.3	93.8	96.3	95.1	89.9	93.6	91.8
12	84.5	91.1	87.8	91.6	95.4	93.5	85.4	91.6	88.4
13	79.5	88.4	83.9	87.8	93.8	90.8	80.5	89.0	84.8
14	73.3	84.8	79.0	82.5	92.4	87.5	74.5	85.8	80.1
15	64.4	79.0	71.6	75.0	87.1	81.1	65.7	80.0	72.8
16-19	30.9	42.1	36.4	42.2	65.0	53.7	33.2	47.0	40.0
20-24	10.4	14.2	12.4	17.0	32.4	24.3	12.3	19.0	15.6
25-29	3.9	5.5	4.7	4.2	7.9	5.9	4.0	6.2	5.1

Бүх насанд эмэгтэйчүүдийн сургуульд хамрагдалт эрэгтэйчүүдийнхээс өндөр, 7-29 насанд 6.6 пунктээр өндөр байна. Хүйсийн энэ урвуу ялгаа шилжигсэдийн дунд 12.4 пунктээр (эрэгтэй 35.1 хувь, эмэгтэй 47.5 хувь) илүү байгаа юм. Харин 7-15 насанд хүйсийн урвуу ялгаа шилжих хөдөлгөөнд ороогүй хүмүүсийн дунд өндөр байна. Энэ нь төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд ороогүй хүмүүсийн ихэнхи нь мал аж ахуй эрхэлдэг бөгөөд тэд охидоо сургуульд явуулж (гэхдээ нас ахисан хойно нь), харин хөвгүүдээ сургуулиас гаргаж байгааг харуулж байна. 15 насанд хүйсийн урвуу ялгаа 15 пункт болжээ.

Төрснөөс хойш шилжигсэдийн дунд ганц бие хүний эзлэх хувийн жин төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд ороогүй хүнийхээс 15.7 пунктээр доогуур байна. Харин шилжигсэдийн дунд гэр бүлтэй хүний эзлэх хувь төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд ороогүй хүнийхээс 12.4 хувиар өндөр байна. Энэ нь шилжигсэд гол төлөв гэр бүлтэйгээ хамт шилжиж байгааг харуулж байна. Төрснөөс хойш шилжигсэдийн хувьд ганц бие болон гэр бүлтэй эрэгтэй хүний эзлэх хувь эмэгтэйчүүдийнхээс өндөр байна. Харин салсан буюу бэлбэсэн хүний эзлэх хувь төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд орсон, ороогүй ялгаагүй эмэгтэйчүүдийн хувьд өндөр байна.

Хүснэгт 7.9 Арван тав, түүнээс дээш насны хүн амын гэрлэлтийн байдал, төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөн, хүйсээр, 2000 оны тооллогоор

Гэрлэлтийн байдал	Шилжих хөдөлгөөнд ороогүй			Шилжигсэд			Бүгд		
	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	468,748	521,462	990,210	281,142	253,020	534,162	749,890	774,482	1,524,372
Ганц бие	44.0	33.8	38.6	24.2	21.5	22.9	36.6	29.8	33.1
Гэр бүлтэй	44.9	47.1	46.1	61.8	54.8	58.5	51.2	49.6	50.4
Хамт амьдарч байгаа	6.8	7.3	7.1	7.9	7.8	7.9	7.2	7.5	7.4
Тусгаарласан	0.9	1.3	1.1	1.1	1.6	1.4	1.0	1.4	1.2
Салсан	1.0	1.8	1.4	1.4	2.3	1.8	1.1	1.9	1.5
Бэлбэсэн	2.4	8.9	5.8	3.5	11.9	7.5	2.8	9.9	6.4

Эмэгтэй шилжигсэдийн дунд бэлбэсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь (11.9 хувь) эрэгтэйчүүдийнхээс (3.5 хувь) гурав дахин өндөр байна. Энэ нь эрэгтэйчүүдийн дундаж наслалт харьцангуй богино байгааг харуулж байна. Мөн түүнчлэн, гэр бүл салсны дараа эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийг бодвол дахин гэрлэх магадлал өндөр байдаг. Өөр нэг сонирхолтой зүйл бол шилжигсэдийн дунд салсан болон бэлбэсэн хүний эзлэх хувь төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд ороогүй хүмүүсийнхээс өндөр байна. Гэр бүл болох, нас барах эсвэл гэр бүл цуцалснаас гэр бүл саринах нь шилжих хөдөлгөөнд ямар нэг байдлаар нөлөөлдөг.

Эрхэлдэг ажлаар хүйсийн ялгаатай байдал төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд ороогүй хүмүүс болон шилжигсэдийн аль алинд ажиглагдаж байна. Гэхдээ энэ ялгаа шилжигсэдийн дунд илүү байна. Хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын албан тушаалын ажилтан, менежер; хөдөө аж ахуйн мэргэшсэн ажилчин; үйлдвэрийн ба худалдааны ажилтан; машин тоног төхөөрөмжийн операторч, угсрагч зэрэг ажил эрхэлж байгаа хүмүүсийн дунд эрэгтэйчүүд давамгайлж байна. Төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөний байдлаар хамгийн их ялгаатай байгаа эрхэлдэг ажил бол хөдөө аж ахуйн мэргэшсэн ажилчин юм. Улсын дүнгээр авч үзэхэд эрэгтэйчүүд (47.3 хувь) эмэгтэйчүүдийг (44.9 хувь) бодвол хөдөө аж ахуйн мэргэшсэн ажилтнаар ажиллах нь илүү байна. Энэхүү хүйсийн ялгаатай байдал төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд ороогүй хүмүүсийн дунд зөвхөн 1.1 пункт, харин шилжигсэдийн дунд 13.2 пункт байна. Эрэгтэйчүүд давамгайлсан бас нэг эрхэлдэг ажил бол хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын албан тушаалын ажилтан, менежер байна. Үүний нэгэн адил, хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын албан тушаалын ажилтан, менежерийн хүйсийн ялгаа төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд ороогүй хүмүүсийн хувьд бага (1.9 пункт) харин шилжигсэдийн хувьд (2.7 пункт) өндөр байна. Машин тоног төхөөрөмжийн операторч, угсрагчийн ажилд мөн эрэгтэйчүүд давамгайлж байна (10.1 пункт). Энэ ялгаа төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд ороогүй хүмүүсийг (эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 8.4 пунктээр илүү) бодвол шилжигсэдийн дунд (эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 12.5 пунктээр илүү) илүү байна. Мэргэжилтний ажил эрхэлж байгаа хүмүүсийн дунд хүйсийн “урвуу” ялгаа хамгийн их байна. Энэ нь төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөний байдлаар авч үзэхэд мөн ажиглагдаж байна. Улсын дүнгээр авч үзэхэд мэргэжилтнээр ажиллаж байгаа эрэгтэйчүүдийн эзлэх хувь (6.2 хувь) эмэгтэйчүүдийнхээс (13.7 хувь) доогуур байна. Энэхүү мэргэжилтнээр ажиллаж байгаа эзлэх хувийн хүйсийн “урвуу”

ялгаа төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд ороогүй хүмүүсийн хувьд (5.2 пункт) бага, шилжигсэдийн хувьд (14.1 пункт) өндөр байна.

Хүснэгт 7.10 Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн ам, эрхэлдэг ажил, төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөний байдал, хүйсээр, 2000 оны тооллогоор

Эрхэлдэг ажил	Шилжих хөдөлгөөнд ороогүй			Шилжигсэд			Бүгд		
	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Ажиллагсадын тоо	261364	250384	511748	159062	108341	267403	420426	358725	779151
Хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын албан тушаалын ажилтан	4.1	2.2	3.2	10.2	5.6	8.3	6.4	3.2	4.9
Мэргэжилтэн	4.2	9.4	6.8	9.4	23.5	15.1	6.2	13.7	9.6
Инженер, техникийн ажилтан	2.3	4.8	3.5	3.9	10.7	6.6	2.9	6.5	4.6
Туслах ажилтан	0.8	2.6	1.7	1.4	5.4	3.0	1.0	3.4	2.1
Үйлчилгээний ажилтан ба дэлгүүр зах дээр худалдаа эрхлэгч	5.3	10.3	7.8	6.9	17.2	11.1	5.9	12.4	8.9
Хөдөө аж ахуйн мэргэшсэн ажилчин	59.2	58.1	58.6	27.8	14.6	22.4	47.3	44.9	46.2
Үйлдвэрийн ба худалдааны ажилчин	7.8	5.5	6.7	12.1	10.1	11.3	9.4	6.9	8.3
Машин тоног төхөөрөмжийн операторч, угсрагч	9.2	0.8	5.1	14.7	2.2	9.6	11.3	1.2	6.7
Бусад	7.1	6.3	6.7	13.7	10.7	12.5	9.6	7.6	8.7

Энэ нь хотод эмэгтэйчүүдийн бараг дөрөвний нэг (23.0 хувь) мэргэжилтнээр ажиллаж байхад эрэгтэйчүүдийн 11.3 хувь ажиллаж байгаатай (Хүснэгт 6.7) нийцэж байна. Товчхондоо, хөдөө аж ахуйн мэргэшсэн ажилтнаар ажиллаж байгаа төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд ороогүй хүмүүсийн хувьд хүйсийн ялгаатай байдал ажиглагдахгүй байна. Харин шилжигсэдийн хувьд эрэгтэйчүүд хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын албан тушаалын ажилтан, менежер; хөдөө аж ахуйн мэргэжсэн ажилчнаар ажиллах нь илүү байхад эмэгтэйчүүд мэргэжилтэн, үйлчилгээний ажилтан ба дэлгүүр, зах зээл дээр худалдаа эрхлэгчээр ажиллах нь илүү байна.

Улсын дүнгээр нийт ажиллагсадын 47.2 хувь нь хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбарт ажиллаж энэ нь ажиллагсадын тоогоороо хамгийн давамгайлсан салбар болж байна. Эдийн засгийн үйл ажиллагааны энэ салбарт төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөний байдлаар нэлээд ялгаатай байдал ажиглагдаж байна. Төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд ороогүй ажиллагсадын хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбарт ажиллаж байгаа хувь (59.3 хувь) шилжигсэдийнхээс (24.1 хувь) 35.3 пунктээр өндөр байна. Харин эдийн засгийн үйл ажиллагааны бусад чиглэлээр ажиллаж байгаа хүний эзлэх хувь шилжигсэдийн хувьд илүү байна. Өөрөөр хэлбэл, шилжигсэд гол төлөв хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбараас бусад салбарт ажиллаж байна. Энэ нь шилжигсэд хот суурин газрыг бараадаж байгааг давхар харуулж байна. Шилжигсэд уул уурхай, олборлох үйлдвэр, боловсруулах үйлдвэр, бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйл ажиллагаа; төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа; боловсрол гэсэн салбарт төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөнд ороогүй хүмүүсээс давамгайлж байна.

Хүснэгт 7.11 Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн ам, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөний байдал, хүйсээр, 2000 оны тооллогоор

Эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн чиглэл	Шилжих хөдөлгөөнд ороогүй			Шилжигсэд			Бүгд		
	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Ажиллагсадын тоо	261,364	250,384	511,748	159,062	108,341	267,403	420,426	358,725	779,151
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	60.1	58.4	59.3	30.0	15.4	24.1	48.7	45.4	47.2
Уул уурхай, олборлох үйлдвэр	1.5	0.4	0.9	6.4	3.5	5.2	3.4	1.3	2.4
Боловсруулах үйлдвэр	5.1	6.8	5.9	7.9	12.9	9.9	6.1	8.6	7.3
Барилга	1.9	0.7	1.3	3.3	1.7	2.6	2.4	1.0	1.8
Цахилгаан, хий үйлдвэрлэл, ус хангамж	2.4	0.8	1.6	3.6	1.9	2.9	2.9	1.1	2.0
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйл ажиллагаа	6.7	7.7	7.2	10.0	14.8	11.9	7.9	9.8	8.8
Зочид буудал, зоогийн газар	0.7	1.9	1.3	0.8	3.0	1.7	0.8	2.2	1.4
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	6.1	2.4	4.3	9.0	5.4	7.5	7.2	3.3	5.4
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	0.3	0.6	0.5	0.6	1.1	0.8	0.4	0.7	0.6
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа	0.9	0.9	0.9	1.9	2.2	2.0	1.3	1.3	1.3
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа	6.8	3.4	5.2	15.8	7.4	12.4	10.2	4.6	7.7
Боловсрол	2.6	7.5	5.0	5.0	16.4	9.7	3.5	10.2	6.6
Эрүүл мэнд, нийгмийн халамж	1.2	5.3	3.2	1.9	10.4	5.3	1.5	6.8	3.9
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	2.1	1.9	2.0	2.8	3.1	2.9	2.4	2.2	2.3
Бусад	1.5	1.5	1.5	1.0	1.1	1.0	1.3	1.4	1.3

Эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн чиглэлээр ажиллагсадыг хүйсээр авч үзэхэд сонирхолтой дүр төрх ажиглагдаж байна. Эмэгтэйчүүд боловсрол (16.4 хувь), эрүүл мэндийн (10.4 хувь) салбарт эрэгтэйчүүдээс (боловсрол 5.0 хувь), (эрүүл мэнд 1.9 хувь) илүү олноороо ажиллаж байна. Харин эрэгтэйчүүд хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй; уул уурхай, олборлох үйлдвэр гэсэн салбарт эмэгтэйчүүдээс илүү олноороо ажиллаж байна. Мөн эрэгтэйчүүд барилга, тээвэр, төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа гэсэн салбарт давамгайлсаар байна. Энэхүү эдийн засгийн үйл ажиллагааны салбар дахь хүйсийн ялгаатай байдал төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд ороогүй болон шилжигсэдийн дунд аль алинд нь хадгалагдаж байгаа бөгөөд шилжигсэдийн дунд бүр ч илүү байна. Хүйсийн ялгаатай байдал хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбарт илүү ажээ. Төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд ороогүй хүмүүсийн хувьд хөдөө ажил ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбарт ажиллаж байгаа хүний эзлэх хувь эрэгтэйчүүд (58.4 хувь), эмэгтэйчүүдийн (59.3 хувь) аль алинд бараг ижил юм. Харин шилжигсэдийн хувьд хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбарт ажиллаж байгаа

эрэгтэйчүүдийн эзлэх хувь (30.0 хувь) эмэгтэйчүүдийнхээс (15.4 хувь) бараг хоёр дахин өндөр байна. Эрэгтэйчүүд (15.8 хувь) эмэгтэйчүүдээс (7.4 хувь) давамгайлж байгаа өөр нэг салбар бол төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа юм. Шилжигсэдийн дунд хамгийн их хүйсийн “урвуу” ялгаатай байгаа эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбар бол боловсрол (11.4 пункт), эрүүл мэнд (8.5 пункт), боловсруулах үйлдвэр (5.0 пункт), бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйл ажиллагаа (4.8 пункт) юм. Товчхондоо, төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд орсон эрэгтэйчүүд хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй, төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа; уул уурхай, олборлох үйлдвэр гэсэн чиглэлд давамгайлж байхад эмэгтэй шилжигсэд боловсрол, эрүүл мэнд, боловсруулах үйлдвэр, худалдааны салбарт давамгайлж байна.

2000 оны тооллогод анх удаа ажил эрхэлж байгаа бүх хүмүүсээс тэдний ажил эрхлэлтийн байдлыг, өөрөөр хэлбэл тэд өөрсдөдөө эсвэл өөр хүнд ажиллаж байсныг асуусан.

Хүснэгт 7.12 Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн ам, ажил эрхлэлтийн байдал, төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөний байдал, хүйсээр, 2000 оны тооллогоор

Ажил эрхлэлтийн байдал	Шилжих хөдөлгөөнд ороогүй			Шилжигсэд			Бүгд		
	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Ажиллагсадын тоо	261364	250384	511748	159062	108341	267403	420426	358725	779151
Гэрээгээр ажиллагч	29.3	32.7	30.9	55.7	68.8	61.0	39.3	43.6	41.3
Ажил олгогч Хувиараа ажиллагч	1.2	0.6	0.9	2.5	1.3	2.0	1.7	0.8	1.3
Хоршооны гишүүн	49.0	16.1	32.9	35.5	17.0	28.0	43.9	16.4	31.2
Гэр бүлийн бизнест цалин авалгүй оролцогч	0.4	0.4	0.4	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5
Бусад	19.7	50.1	34.6	4.7	12.0	7.6	14.0	38.6	25.3
	0.4	0.2	0.3	1.0	0.3	0.7	0.6	0.2	0.4

Ажил эрхлэлтийн байдал хүйсээр нилээд ялгаатай байв. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль алины ажил эрхлэлтийн байдлын хамгийн өндөр хувь гэрээгээр ажиллагч (41.3 хувь), үүний дараа хувиараа ажиллагч (31.2 хувь) орж байна. Хүснэгт 7.12-д ажил эрхлэлтийн байдлын ялгааг төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөний байдлаар харуулав. Гэрээгээр ажиллагч, гэр бүлийн бизнест цалин авалгүй оролцогчид төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөний байдлаар хамгийн их ялгаатай байна. Төрснөөс хойш шилжих хөдөлгөөнд орсон ажил эрхэлж байгаа хүмүүсийг (61.0 хувь) шилжих хөдөлгөөнд ороогүй хүмүүстэй (30.9 хувь) харьцуулахад гэрээгээр ажиллах нь хоёр дахин илүү байна. Харин шилжих хөдөлгөөнд ороогүй хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн хувиараа хөдөлмөр эрхлэх нь (32.9 хувь) шилжигсэдийг бодвол (28.0 хувь) илүү байна. Шилжих хөдөлгөөнд ороогүй ажиллагсад (34.6 хувь) шилжигсэдийг (7.6 хувь) бодвол гэр бүлийн бизнест цалин авалгүй оролцогчоор ажиллах нь илүү ажээ.

Ажил эрхлэлтийн байдлын хүйсийн ялгаа төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөний байдлаар мөн ялгаатай байна. Ажил эрхлэлтийн байдлын хүйсийн ялгаа бусад үзүүлэлттэй адилгүйгээр шилжигсэдийг бодвол шилжих хөдөлгөөнд ороогүй хүмүүсийн хувьд илүү байна. Шилжих хөдөлгөөнд ороогүй, ажил эрхэлж байгаа эрэгтэйчүүд хувиараа ажил эрхлэх нь (49.0 хувь) эмэгтэйчүүдээс (16.1 хувь) илүү байхад эмэгтэйчүүд (50.1 хувь) гэр бүлийн бизнест цалин авалгүй оролцох нь эрэгтэйчүүдээс (19.7 хувь) илүү ажээ. Ажил эрхэлж байгаа шилжигсэдийн хувьд эрэгтэйчүүд (35.5 хувь) хувиараа ажил эрхлэх нь эмэгтэйчүүдээс (17.0 хувь) илүү байна. Харин ажил эрхэлж байгаа эмэгтэй шилжигсэд (68.8 хувь) эрэгтэйчүүдийг бодвол гэрээгээр ажиллах нь илүү (55.7 хувь) байна.

